

ЗӨВШӨӨРЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Зөвшөөрлийн зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдааны 1 дүгээр тэмдэглэлд:

“ХЭЛЭЛЦСЭН нь: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Сангийн яамнаас боловсруулж, ирүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн дараах ДҮГНЭЛТ гаргаж байна:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “2.39. Банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх”, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “2.52.Хөндлөнгийн хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх”, “2.53.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх”, “2.54.Гадаадын даатгалын брокер Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар нээх” гэж тус тус нэмэхийг дэмжив.

2. “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.14 дахь заалтын “зуучлагчийн” гэснийг “брокерын” гэж өөрчилсүгэй” гэснийг, “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.13 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай” гэснийг, “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.16 дахь заалтын “урт хугацааны” гэснийг “амьдралын” гэж, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.26 дахь заалтын “албан журмын” гэснийг “заавал” гэж, 2.27 дахь заалтын “албан журмын даатгагчдын” гэснийг “заавал даатгалын” гэж тус тус өөрчилсүгэй” гэснийг, “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.15 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай” гэснийг тус тус дэмжив.” гэжээ.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ЗӨВШӨӨРЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.АМАРБАЯСГАЛАН